

Корона вирустай холбоотой мэдээлэл

Корона вирус нь нэг шинэ төрлийн өвчний шалтгаан болж байна.

Энэ өвчин маш хурдан тархаж байна.

Өвчилсөн хүн бусдад уг өвчнийг халдаах аюултай.

Эндээс та корона вирусны талаар мэдээлэл авах боломжтой.

Мөн өөрийгөө хамгаалахын тулд юуг анхаарах талаар.

Чухал: Хэн нэгэн хүн корона вирусаар өвчилсөн бол?

Тэр хариуцах байгууллагад хандвал?

Энэ тохиолдолд бид түүнд анхаарал халамжтай ханд

Бидний хүсэлт:

Бүх хүмүүс өвчтэй хүнд анхаарал халамжтай хандах.



Корона вирус өвчний тухайд ?

Энэ өвчин нь уушгийг хүндээр өвчлүүлдэг.

Хэн нэгэн хүн корона вирусны халдвар авсан бол:

Түүнд ханиалгах болон найтаах, нус гоожих

Эсвэл халуурах, хоолой өвдөх

Заримдаа мөн гэдэс гүйлгэх зэрэг шинж тэмдэг илэрнэ

Хэн нэгэн хүн корона вирусны халдвар авсан бол?

Шинж тэмдэг илрэх хугацаа нь 14 хоног

хүртэл үргэлжлэх магадлалтай .




Та корона вирусны халдвар авахгүйн тулд юуг анхаарах хэрэгтэй вэ?

Эрүүл ахуйн шаардлагыг хангах.

Эрүүл ахуйн дэглэм хувийн ариун цэвэр сахих нь халдвараас сэргийлэхэд зайлшгүй шаардлага арай.

Дараахь эрүүл ахуйн дэглэмийг мөрдөх нь чухал:



- Бусад хүмүүс рүү чиглэж ханиалгахгүй байх!
Бусад хүмүүс рүү чиглэж найтаахгүй байх!
Ханиалгах найтаалгах тохиолдолд хүмүүсээс өөр чиглэл рүү эргэж харах.
Хүмүүсээс доод тал нь 1 метерийн зай барих.
1 метер нь алдалсан гарнаас арай илүү урттай.
2 метер байвал илүү найдвартай.
- Та ханиалгах болон найтаах бол?
Энэ тохиолдолд цаасан салфетик хэрэглэх нь чухал.
Цаасан салфетикийг нэг л удаа хэрэглээрэй.
Дараа нь салфетикийг хогийн сав руу хийх.
- Та ханиалгах болон найтаах бол?
Мөн танд цаасан салфетик байхгүй бол?
Энэ тохиолдолд тохойн дотор тал руу ханиалгах нь зүйтэй.

- **Чухал: Гараа угаах!**

Гараа тогтмол сайтар угаах хэрэгтэй.

Ялангуяа ханиалгаж найтаасны дараа.

Мөн хамраа цэвэрлэсний дараа.

Та ус болон саван хэрэглээрэй!

Гар угаахдаа хамгийн багадаа 20 сек. зарцуулаарай.



ЗӨВХӨН эрүүл ахуйн дэглэмийг сахих нь халдвараас сэргийлэхэд хангалттай биш.

Дараахь дэглэмийг бас анхаараарай:

Бусад хүмүүстэй гар барьж мэндлэхээс татгалзах хэрэгтэй.


Мөн тэвэрч мэндэлсний хэрэггүй.

- Ханиалгаж найтаалгаж буй хүмүүсээс дор хаяж 1 метрийн зай бариарай.
1 метер нь алдалсан гарнаас арай илүү урттай.
2 метер байвал илүү найдвартай.

- Цонхоо тогтмол онгойлгож байгаарай.
Ингэснээр тасалгаа цэвэр агаартай болно.

- Зарим хүмүүс хурдан халдвар авах эрсдэлтэй.
Жнь. өндөр настай хүмүүс

- Олон хүн цугларсан газар руу ойртохгүй байх нь зүйтэй.



**Би корона вирусаар халдварласан байж болзошгүй .
Би энэ тохиолдолд яах ёстой вэ?**

Та хэрэв:

би корона вирусны халдвар авсан байх гэж бодож байвал
Эрүүл ахуйн дэглэмийг сайн анхаарч сахих хэрэгтэй!
Та эмчид мэдэгдэх хэрэгтэй.
Жнь. өрхийн эмчдээ



Чухал:

Та эхлээд эмч рүүгээ утсаар ярих хэрэгтэй!
Та эмч рүү шууд явж очиж **болохгүй!**
Өрхийн эмч буюу түүний ажилтан танд:
Юу хийх ёстойг хэлж өгөх болно.



Бусад мэдээлэл

Та корона вирусны талаар илүү мэдээлэл авахыг
хүсэж байна уу?
Эсвэл танд өөр асуулт байна уу?
Эндээс та интернет хаяг болон утасны дугаар олох болно.
Тэндээс та илүү мэдээллийг олж авах болно.



Утасны дугаарууд

Мужийн эрүүл мэндийн байгууллага

Танд корона вирусны талаар асуулт байна уу.

Nordrhein-Westfalen мужийн эрүүл мэндийн газар тусгай утасны дугаар гаргасан.

Бүх иргэд энэ дугаар руу залгах боломжтой.

Утсаар ярих цагийн хуваарь:

Даваа гаргаас Баасан гараг хүртэл 9.00 цагаас 18.00 цаг хүртэл

Утасны дугаар: **0211 911 91 001**



Rhein Sieg дүүргийн эрүүл мэндийн газар

Танд корона вирусны талаар асуулт байна уу?

Тэгвэл та Rhein Sieg дүүргийн эрүүл мэндийн газар руу залгаж болно .

Утсаар ярих цагийн хуваарь:

Даваа гаргаас ням гараг хүртэл 8.00 цагаас 20.00 цаг хүртэл

Утасны дугаар: **02241 13 33 33**

Эмч нарын холбоо

Та өвчтөнд үзүүлэх үйлчилгээний газар руу залгаж болно.

Энэ нь герман даяар үйлчилнэ.

Утсаар ярих цагийн хуваарь:

Даваа гаргаас Баасан гараг хүртэл 8.00 цагаас 16.00 цаг хүртэл

Утасны дугаар: **116 117**

Хотын код хийх шаардлагагүй.

Интернет хаяг

Robert-Koch-Institut



(Роберт Кох институт)

Роберт Кох институт нь

Эрүүл мэндийн яаманд харьяалагддаг.

Роберт Кох институтэд халдвар өвчнийг
судлах эрдэмтэд ажилладаг.

Олон хүмүүс корона вирусны талаар асууж байгаа.

Энэ бүх асуултыг Роберт Кох институт эмхэтгэж өөрийн
вебсайтаар

дамжуулан хүргэж байна.

Дараахь вебсайтаас энэхүү асуултуудад хариу авах боломжтой.

https://www.rki.de/SharedDocs/FAQ/NCOV2019/FAQ_Liste.html

Эрүүл мэндийн асуудал эрхлэх улсын төв газар

Эрүүл мэндийн асуудал эрхлэх улсын төв газар нь мөн корона
вирустай холбоотой асуулт хариултыг эмхэтгэн хүргэж байгаа.

